

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/42/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас:51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор:А.Даваадорж Утас: 51-261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn Ирмүүн хантайшир аудит ХХК-ийн захирал: Д.Бямбацэрэн Утас:77550809 Цахим хаяг: irmuunkhantaishir@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа	9
Компанийн үйл ажиллагааны чиглэл	9
3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	10
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин.....	11
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1. Албан шаардлага.....	15
5.2 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
БОННУ	Байгаль орчин нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын тайлан
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ
ҮЙЛДВЭР ТӨХХК-ИЙН ЗАХИРАЛ
Д.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА

2026.03.23 № 06/762
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 31,203.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 593.3 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй;
- Эрдэнэс Монгол ХХК-аас Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-д олгосон урт хугацаат зээл болон хүүгийн өглөгийн үлдэгдэл 2025 оны эцэст 1,296,015.2 сая төгрөгт хүрч, компанийн нийт өр төлбөрийн 85.6 хувийг бүрдүүлсэн нь санхүүгийн байдлын үндсэн үзүүлэлтүүдийг доройтуулсан байна. Тайлант хугацаанд зээлийн хүүгийн зардал 27,631.4 сая төгрөгт хүрч, 62,699.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллахад нөлөөлжээ. Компани нь хүүгийн зардлыг бууруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй;
- Монголиан транс ложистик ХХК-аас авах төмөр зам ашигласны төлбөртэй холбоотой үүссэн 688.1 сая төгрөгийн авлага, Батлан хамгаалах яамтай байгуулсан газрын тосны үйлдвэрийн хотхоны 95 айлын орон сууц барих гэрээний

- урьдчилгаа төлбөр 2,058.2 сая төгрөг нийт 2,746.3 сая төгрөгийг барагдуулах арга хэмжээг хэрэгжүүлээгүй, хугацаа хэтэрсэн авлага үүсгэсэн;
- Тайлант оны эдийн засгийн зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөнд тодотгол ажилласан боловч бичиг хэрэг, шатах тослох материалыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүй 76.4 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.16 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хуваарилалт”, “толилуулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 02 дугаар албан даалгавраар 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах хүрээнд “Газрын тос боловсруулах үйлдвэр” төслийн дөрөвдүгээр шатны инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын гэрээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, мөн тус үйлдвэрт шаардагдах газрын тосны хайгуулын ажлыг хөрөнгө оруулагч талуудтай хамтран эхлүүлэхийг холбогдох байгууллагуудад үүрэг болгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бид Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд тусгагдсан дараах асуудалд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн анхаарлыг хандуулж байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 205 дугаар тогтоолын дагуу Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Газрын тос боловсруулах үйлдвэрийн ЕРС-01 багцын 312,075.9 сая төгрөгийн өртөг бүхий барилга байгууламж, 2025 оны 656 дугаар тогтоолын дагуу 42 нэр төрлийн нийт 38,319.4 сая төгрөгийн оффис, орон сууц болон дэд бүтцийн зориулалттай хөрөнгийг үндсэн хөрөнгөнд нэмж бүртгэсэн байна.

Мөн байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор, норматив баримт бичгээр тогтоогдсон, ашиглалтын явцад тогтмол нөхөн бүрдүүлэгддэг шинжтэй 2,375 нэр төрлийн 1,045.7 сая төгрөгийн өртөг бүхий бууршгүй нөөцийг бараа материалын бүрэлдэхүүнд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 -р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	2,990,011,847.07	2,119,129,602.75
1.1.02	Дансны авлага	707,698,164.40	903,795,042.80
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	1,001,979,720.17	707,260,913.54
1.1.04	Бусад авлага	48,420,000.00	49,047,800.00
1.1.06	Бараа материал	8,761,765.18	1,104,753,997.98
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	47,175,904,580.73	27,315,940,827.64
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	51,932,776,077.55	32,199,928,184.71
1.2.01	Үндсэн хөрөнгө	106,758,475,104.80	1,658,794,829,096.33
1.2.02	Биет бус хөрөнгө	11,128,726,063.80	11,119,530,725.80
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,027,137,857,666.01	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,145,025,058,834.61	1,669,914,359,822.13
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,196,957,834,912.16	1,702,114,288,006.84
2.1.1.01	Дансны өглөг	317,229,951,187.22	57,232,152,775.58
2.1.1.03	Татварын өр	793,238.56	586,651,220.05
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	159,737,660,494.96
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	317,230,744,425.78	217,556,464,490.59
2.1.2.01	Урт хугацаат зээл	191,131,754,278.32	207,184,825,671.51
2.1.2.02	Ур хугацаат зээлийн хүү	110,074,468,050.29	137,705,893,477.68
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	639,194,688,634.70	951,124,534,531.99
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	940,400,910,963.31	1,296,015,253,681.18
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,257,631,655,389.09	1,513,571,718,171.77
2.3.01	Өмч төрийн	10,000,000.00	10,000,000.00
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	11,022,738,200.00	323,107,539,013.47
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(71,706,558,676.28)	(134,574,969,178.40)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	(18,470,386,552.28)	(62,702,408,533.81)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(53,236,172,124.00)	(71,872,560,644.59)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(60,673,820,476.93)	188,542,569,835.07
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,196,957,834,912.16	1,702,114,288,006.84

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 -р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,084,229,791.82	777,711,054.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	728,294,490.75	568,731,968.19
3	Нийт ашиг (алдагдал)	355,935,301.07	208,979,085.81
4	Түрээсийн орлого	-	233,349,350.91
5	Хүүний орлого	10,921,898.73	9,797,349.24
8	Бусад орлого	3,144,422.70	22,867,254.62
8.1	Орлогын дүн	14,066,321.43	266,013,954.77
10	Ерөнхий ба удирдлагын зардал	11,951,390,724.34	23,790,115,824.95
11	Санхүүгийн зардал	345,998,427.95	1,852,388,256.86
12	Бусад зардал	615,779,170.90	47,488,996.73
12.1	Зардлын дүн	12,913,168,323.19	25,689,993,078.54
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(5,926,127,671.96)	(37,484,272,490.01)
17.1	Олз, гарзын дүн	(5,926,127,671.96)	(37,484,272,490.01)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(18,469,294,372.65)	(62,699,272,527.97)
19	Орлогын татварын зардал	1,092,179.63	3,136,005.84
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(18,470,386,552.28)	(62,702,408,533.81)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(18,470,386,552.28)	(62,702,408,533.81)
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(18,470,386,552.28)	(62,702,408,533.81)

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,000,000.00	9,384,783,200.00	629,141,858.60	629,141,858.60
02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
03	Залруулсан үлдэгдэл	-	-	(53,236,172,124.65)	(43,841,388,924.65)
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(18,470,386,552.28)	(18,470,386,552.28)
06	Өмчид гарсан өөрчлөлт	-	1,637,955,000.00	-	1,637,955,000.00
07	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,000,000.00	11,022,738,200.00	(71,706,558,676.93)	(60,763,820,476.93)
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(166,001,967.66)	(166,001,967.66)
11	Залруулсан үлдэгдэл	10,000,000.00	11,022,738,200.00	(71,872,560,644.59)	(60,839,822,444.59)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(62,702,408,533.81)	(62,702,408,533.81)
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	312,084,800,813.47	-	312,084,800,813.47
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	10,000,000.00	323,098,683,397.47	(134,574,969,178.40)	188,542,569,835.07

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	335,769,924.83	764,612,562.66
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	260,408,924.00	250,398,210.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,667,150.00	19,406,438.30
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	72,693,850.83	110,126,526.36
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,577,641,200.82	8,537,060,994.31
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,174,508,660.73	3,779,252,773.34
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	816,796,498.43	1,057,946,315.82
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	80,936,979.42	94,106,109.87
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	979,337,369.61	1,395,665,388.71
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	69,739,931.78	128,730,794.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	22,999,999.97	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	602,659,230.44	661,500,612.53
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	50,396,148.80	42,014,090.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	780,266,381.64	1,377,844,910.04
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,241,871,275.99)	(7,772,448,431.65)
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,137,227,155.00	9,152,838,964.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	295,500,000.00	369,740,100.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	2,900,000.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,841,727,155.00	8,780,198,864.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(8,137,227,155.00)	(9,152,838,964.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	14,402,103,586.00	16,053,071,393.19
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	14,402,103,586.00	16,053,071,393.19
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	14,402,103,586.00	16,053,071,393.19
3.4	Валютын ханшийн зөрүү	(85,811.11)	1,333,758.14
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	22,919,343.90	(870,882,244.32)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,966,920,880.95	2,990,011,847.07
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,990,011,847.07	2,119,129,602.75

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			-	-	-	-	-	-	-
1	Нийт орлого	м.төг	1,098,296.1	1,014,207.4	1,043,725.0	(54,571.1)	95.0	29,517.6	102.9
2	Нийт зардал	м.төг	19,568.682.7	76,630,483.4	63,745,064.0	44,176,381.3	325.6	(12,885,419.4)	83.2
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	5,935,443.4	9,261,281.1	8,089,365.3	2,153,921.9	136.3	(1,171,915.7)	87.3
3	Татварын өмнөх ашиг	м.төг	(18,469,294.4)	(75,616,276.0)	(62,699,272.5)	(44,229,978.1)	339.5	12,917,003.5	82.9
4	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	(18,470,386.6)	(75,616,976.0)	(62,702,408.5)	(44,232,021.9)	339.5	12,914,567.4	82.9
5	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	959,415.7	1,121,969.9	1,130,159.0	170,743.3	117.8	8,189.1	100.7
	а/ Орлогын татварт	м.төг	1,358.9	700.0	3,136.0	1,777.1	230.8	2,436.0	448.0
	б/ НӨТ	м.төг	-	-	-	-	-	-	-
	в/ НДШ	м.төг	470,052.2	560,454.0	559,850.0	89,797.8	119.1	(604.0)	99.9
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	339,231.2	411,768.8	411,768.8	72,537.6	121.4	0.0	100.0
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	-	-	-	-	-	-	-
	э/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	326.3	600.0	1,305.0	978.7	399.9	705.0	217.5
	ж/ Бусад татварт (Газрын төлбөр)	м.төг	148,447.1	148,447.1	154,099.2	5,652.1	103.8	5,652.1	103.8
6	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	-	-	-	-	-	-	-
7	Нийт ажиллагсдын тоо	хүн	106	100	92	(14)	86.8	(8.0)	92.0
8	Нийт цалингийн сан	м.төг	3,911,618.0	4,185,424.4	3,979,677.0	68,059.0	101.7	(205,747.4)	95.1
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	3,075.2	3,487.9	4,325.7	1,250.5	140.7	837.9	124.0
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	-	-	-	-	-	-	-
11	Хөрөнгө оруулалт	м.төг	298,934,446.7	633,251,150.8	296,558,601.3	(2,375,845.4)	99.2	(336,692,549.5)	46.8
12	Нийт авлага	м.төг	1,758,098.0	1,650,694.3	28,976,044.6	27,217,946.6	1,648.1	27,325,350.3	1,755.4
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	-
13	Нийт өглөг	м.төг	1,257,631,655.4	1,978,022,508.5	1,513,571,718.2	255,940,062.8	120.4	(464,450,790.3)	76.5
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	317,230,744.4	377,227,279.5	217,556,464.5	(99,674,279.9)	68.6	(159,670,815.0)	57.7
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	940,400,911.0	1,600,795,229.0	1,296,015,253.7	355,614,342.7	137.8	(304,779,975.3)	81.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нь Дорноговь аймагт газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулж, үр ашигтай ажиллуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 1 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан компанийн дүрэмд үндсэн үйл ажиллагааны хүрээнд 21 үйл ажиллагааг эрхлэн явуулахаар тусгасан байна.

- Газрын тос боловсруулах үйлдвэр барьж байгуулах, ашиглалтад оруулах;
- Стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж борлуулах;
- Стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж борлуулах;
- Түүхий тос дамжуулах хоолой барьж байгуулах

Компанийн үйл ажиллагааны чиглэл

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль зэрэг хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд тус газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал:

- Үндэсний баялгийн сангийн тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавар;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар гаргасан байна.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Бүтэц орон тоог өөрчлөн баталж, дотоод хяналтын алба байгуулан ажиллаж байгаа ч орон тоо дутуу дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөө, хийсэн ажлын тайлан нь компанийн санхүүгийн үйл ажиллагааг хамаараагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нь бүртгэлийн үйл ажиллагаанд нийцүүлэн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна. Компани нь 2024 оны 8 сард зөвлөх үйлчилгээний ажлын дагуу нягтлан бодох бүртгэлийн дансны нэгдсэн төлөвлөгөө, үйл ажиллагааны түрээсийн толилуулга ба тодруулга, өртөг, зардлын бүртгэлийн бодлого, үндсэн хөрөнгийн ангилал, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, үндсэн хөрөнгийн толилуулга ба тодруулга гэсэн чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад болон тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн байна

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 505,156.4 сая төгрөгөөр буюу 42.2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31	Өөрчлөлт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,990,011.8	2,119,129.6	(870,882.2)
Дансны авлага	1,758,097.9	1,660,103.8	(97,994.1)
Бараа материал	8,761.8	1,104,754.0	1,095,992.2
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	47,175,904.6	27,315,940.8	(19,859,963.8)
Үндсэн хөрөнгө	106,758,475.1	1,658,794,829.1	1,552,036,354.0
Биет бус хөрөнгө	11,128,726.1	11,119,530.7	(9,195.3)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,027,137,857.7	-	(1,027,137,857.7)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,196,957,834.9	1,702,114,288.0	505,156,453.1
Богино хугацаат өр төлбөр	317,230,744.4	217,556,464.5	(99,674,279.9)
Урт хугацаа өр төлбөр	940,400,911.0	1,296,015,253.7	355,614,342.7
Эздийн өмчийн дүн	(60,673,820.5)	188,542,569.8	249,216,390.3
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,196,957,834.9	1,702,114,288.0	505,156,453.1

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан бараа материал, урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгө, бусад эргэлтийн бус хөрөнгө, богино болон урт хугацаат өр төлбөр, эздийн өмчийн дансууд байна. Тухайлбал:

- Бараа материалын дансны үлдэгдэл 1,096.0 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2024 оны 205 дугаар тогтоолын дагуу Kalpataru Projects International Limited-ээс төсөл хэрэгжүүлэгчид хүлээлгэн өгсөн 2,375 нэр төрлийн нийт 1,045.7 сая төгрөгийн бууршгүй нөөцийг бараа материалын бүрэлдэхүүнд орлогоор тусгасантай холбоотой;
- Урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл 19,856.0 сая төгрөгөөр буурсан нь Noginco International Cooperation Ltd-д олгосон дамжуулах хоолойн барилгын ажлын урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэлээр хааж, холбогдох ажлыг хүлээн авсантай холбоотой;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,552,036.3 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2025 оны 656 дугаар тогтоолын дагуу 42 нэр төрлийн 38,319.5 сая төгрөгийн барилга, байгууламжийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн, мөн тус газрын 2024 оны 205 дугаар тогтоолын дагуу Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн ЕРС-01 багцын 312,075.9 сая төгрөгийн барилга байгууламж, 8.8 сая төгрөгийн өртөгтэй газрыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэнтэй холбоотой;
- Богино хугацаат өр төлбөрийн данс 99,674.3 сая төгрөгөөр буурсан нь Норинко Интернэйшнл Кооперэйшн компанийн гэрээт ажлын өр төлбөр 111,836.6 сая төгрөгийг барагдуулсантай холбоотой;
- Урт хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл тайлант хугацаанд 355,614.3 сая төгрөгөөр өссөн нь Монгол Улсын Хөгжлийн банкттай байгуулсан ЗГ-МГТ-3 2018-43 тоот гэрээ, “Эрдэнэс Монгол” ХК-тай байгуулсан ЭМГЛ-31/ЗГ-04/20230407 тоот гэрээ, “Эрдэнэс Таван Толгой” ХК-тай байгуулсан ЭТТ-2022/225 09/22 тоот гэрээ, мөн Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банкттай байгуулсан MR-01/2022 тоот гэрээний дагуу авсан урт хугацаат хөрөнгө оруулалтын зээлийн үлдэгдэл 327,982.9 сая төгрөгөөр, хүүгийн өглөг 27,631.4 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй тус тус холбоотой;
- Эздийн өмчийн дансны үлдэгдэл тайлант хугацаанд 249,216.4 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2024 оны 205 дугаар тогтоолын дагуу Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Газрын тос боловсруулах үйлдвэрийн ЕРС-01 багцын 312,075.9 сая төгрөгийн өртөг бүхий барилга байгууламж, мөн 8.8 сая төгрөгийн өртөгтэй газрыг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Компани нь санхүүгийн Unicus программыг ашигладаг бөгөөд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нийцсэн. Мөн оффисын хэрэглээнд Office 635, бичиг хэрэг цахим бүртгэлийн Able систем, дотоод сүлжээний хамгаалалтын firewell fortinet, вирус хамгаалалтын kaspersky программуудыг тус тус ашиглаж байна.

Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгаагаар компани нь “Даймонд” санхүүгийн программ хангамжийг ашиглан нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд уг программ нь компанийн бүртгэл, тайлагналын хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, хөрөнгө /боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 21 дүгээр тогтоолоор компанийн 2025 оны үйл ажиллагааны төсвийг баталсан бөгөөд уг төсөвт 2025 оны 15 дугаар тогтоолоор тодотгол хийсэн байна. Тодотголоор нийт орлогыг 1,014.2 сая төгрөг, нийт зардлыг 76,630.5 сая төгрөг байхаар, татвар төлөхийн өмнөх алдагдлыг 75,616.3 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Тайлант онд 1,043.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж 63,742.9 сая төгрөгийн зардал гарган, 62,699.2 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх алдагдалтай ажилласан.

Нийт орлого тайлант онд 1,043.7 сая төгрөгт хүрч, төсөвлөснөөс 29.5 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар давсан нь төлөвлөгөөнд харьцангуй бага түвшинд тусгагдсан түрээсийн орлого гүйцэтгэлээр 233.3 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 117.9 сая төгрөгөөр давж биелснээс хамаарсан байна.

Харин төмөр зам ашиглалтын орлого төлөвлөснөөс 113.4 сая төгрөгөөр дутуу байгаа нь нийт орлогын өсөлтийг тодорхой хэмжээнд саармагжуулсан боловч бусад болон хүүний орлогын эерэг нөлөөгөөр нийт орлого төлөвлөсөн түвшинг давсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 63,742.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 12,914.9 сая төгрөг 17.1 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь батлагдсан орон тооноос дутуу орон тоогоор ажиллан цалингийн зардалд 104.9 сая төгрөгийн, сонгон шалгаруулалт амжилтгүй болсонтой холбоотой төмөр зам арчлал хамгаалалын зардал 300.0 сая төгрөгийн, цахилгаан дамжуулах агаарын шугмын арчлалт, хамгаалалтын зардал 249.5 сая төгрөгийг тус тус зарцуулаагүй, мөн зээлийн хүүгийн зардал 443.2 сая төгрөгөөр, гадаад валютын ханшийн зөрүү төсөвлөснөөс 11,203.7 сая төгрөгөөр бага байсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

1. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 сарын 31-ны өдрийн 19 дугаар тогтоолоор нийт 128 хүний орон тоо бүтэц баталж, гүйцэтгэлээр 116 ажилтны орон тоотойгоор ажилласан байна.
2. Тайлант хугацаанд албан томилолтын зардалд 195.2 сая төгрөг төсөвлөн гүйцэтгэлээр гадаад албан томилолтын зардалд 160.5 сая төгрөг, дотоод албан томилолтын зардалд 80.1 сая төгрөг нийт 240.6 сая төгрөг гарч нийт 45.4 сая төгрөг илүү зарцуулсан байна.
3. Сургалтын зардалд 40.1 сая төгрөгийг төлөвлөсөн ба гүйцэтгэлээр компанийн нийт ажилчдыг хувь хүний хөгжил, компанийн засаглал байгууллагын соёл, сэтгэл зүйн сургалтад хамруулан 7.5 сая төгрөг, татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох сургалтад 3 ажилтан хамруулан 0,7 сая төгрөг, өмгөөллийн сургалтад 5 ажилтан хамруулан 20.0 сая төгрөг нийт 35.4 сая төгрөг зарцуулсан байна.
4. Тус компанид төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой болон хэвлэл мэдээллийн зардлууд гараагүй ба хоол унааны мөнгө олгодоггүй байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 9 сарын 4-ний өдрийн 16 дугаар тогтоолоор нийт 51 нэр төрлийн 8,870.4 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөгөө батлуулан гүйцэтгэлээр 45 аж ахуй нэгжтэй 8,238.3 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулан ажилласан байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй нийт 76,4 сая төгрөгийн ажил гүйлгээг хийсэнтэй холбоотой албан шаардлага хүргүүлсэн.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК -ийн үйл ажиллагааг сайжруулах холбоотой үндсэн хөрөнгийн элэгдлийг зөв тооцож бүртгэх, үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллагад хүргэж шийдвэрлүүлэх, талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Ирмүүн хантайшир аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Норхлоо, аудиторын туслах Д.Отгонсэнгээ нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг менежер Г.Сэр-Од, захирал Д.Бямбацэрэн нар, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитын менежер Д.Энхдалай газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/40 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн зардлын 19,568.6 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 97.8 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа хангамжийг хязгаарласантай холбогдуулан сургалтыг онлайн хэлбэрээр хийж, дутуу сул орон тоог хэвээр хадгалан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзэхэд хуулийн дагуу 29 нэр төрлийн 11,904.3 сая төгрөгийн орлогын гүйлгээ, 150 нэр төрлийн 9,531.7 сая төгрөгийн зарлагын гүйлгээний мэдээллүүдийг бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 завсрын аудитын үр дүн

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-ийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хамруулан завсрын аудит гүйцэтгэж, мөнгөн хөрөнгө, авлага бараа материалын дансанд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар илэрсэн 850.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгч, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин нягталж дүнг аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 10,327.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 10,322.3 сая төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага, 3.8 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж, өгснийг бүрэн хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн. Аудитын шийдвэрийн хэрэгжилт дунджаар 99.1 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	1	1,245.8	1	1,245.8	100.0
2	Албан шаардлага	5	10,322,313.1	5	10,322,313.1	100.0
3	Зөвлөмж	5	3,881.6	5	3,881.6	98.0
	Нийт дүн	11	10,327,440.5	11	10,327,440.5	99.1

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн дараах асуудлууд компанийн удирдлага болон дээд шатны төсөв захирагч анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Газрын тосны боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тодотголд ЕРС 02 болон ЕРС 03 багц ажлуудыг 2026 оны сүүлчээр дуусахаар тооцсон байна. Гэсэн хэдий ч гүйцэтгэгч болон захиалагчаас үл хамаарах, зээлийн шугамд хамруулах процесс удаашрах, урьдчилгаа төлбөр олон сараар саатах зэрэг санхүүгийн болон зохицуулалтын шинжтэй хүндрэлүүдээс шалтгаалан ажлын явцад хоцрогдол гарч одоогийн нөхцөл байдлаар 2027 онд дуусах хандлагатай байна.
- Эрдэнэс Монгол ХХК-аас Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-д олгосон урт хугацаат зээл болон хүүгийн өглөгийн үлдэгдэл 2025 оны эцэст 1,296,015.2 сая төгрөг хүрч, компанийн нийт өр төлбөрийн 85.6 хувийг бүрдүүлсэн байна. Тайлант оны зээлийн хүүгийн зардал 27,631.4 сая төгрөг болж 62,699.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллахад нөлөөлжээ. Компани нь хүүгийн зардлыг бууруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 31,203.6 сая төгрөгийн алдаа¹ илэрсэнд 30,454.0 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 749.6 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.1. Албан шаардлага

Илрүүлэлт 1: "Монголиан транс ложистик" ХХК-аас авах төмөр зам ашигласны төлбөртэй холбоотой үүссэн 688.1 сая төгрөгийн авлага, батлан хамгаалах яамтай байгуулсан газрын тосны үйлдвэрийн хотхоны 95 айлын орон сууц барих гэрээний урьдчилгаа төлбөр 2,058.2 сая төгрөг нийт 2,746.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээг хэрэгжүүлээгүй хугацаа хэтэрсэн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлагаа хүргүүлсэн.

Илрүүлэлт 2: Тайлант оны эдийн засгийн зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөнд тодотгол хийж хэрэгжилтийг ханган ажилласан боловч үйл ажиллагааны батлагдсан зардал, гүйцэтгэлээрх зардлын ангилал зөрүүтэй мөн бичиг хэрэг, шатах тослох материалыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүй 76.4 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнд тусгалгүй шууд худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 3: Эрдэнэс Монгол ХХК-аас Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-д олгосон урт хугацаат зээл болон хүүгийн өглөгийн үлдэгдэл 2025 оны эцэст 1,296,015.2 сая төгрөг хүрч, компанийн нийт өр төлбөрийн 85.6 хувийг бүрдүүлсэн байна. Тайлант оны зээлийн хүүгийн зардал 27,631.4 сая төгрөгт болж 62,699.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллахад нөлөөлжээ. Компани нь хүүгийн зардлыг бууруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”,

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 16-д "Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана", 20-д "Энэ зүйлийн 16-д заасан зөвшөөрөлгүйгээр төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь зээл авах, үнэт цаас гаргахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор авсан зээлийн хүүгийн түвшинг багасгаж алдагдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд 2024 онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт оруулан үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацааг нарийвчлан тогтоосон боловч хэрэгжилт хангалтгүй тайлант хугацаанд 126 ширхэг үндсэн хөрөнгийн 156.2 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, 20 дугаар зүйлийн 20.2.6-дэд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн элэгдлийг ашиглалтын хугацаанд нийцүүлэн дахин тооцож дутуу тусгасан 156.2 сая төгрөгийн элэгдлийн зардлыг санхүүгийн тайланд залруулах, цаашид элэгдлийн тооцоололд тогтмол дотоод хяналт хэрэгжүүлэх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 338 ширхэг 593.3 сая төгрөгийн анхны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож эрх бүхий байгууллагад саналыг хүргэж шийдвэрлүүлэн, бүртгэлд тусгаж ашиглалтад тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Үндсэн хөрөнгийн нийт 126 ширхэг үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацааг зөрүүтэй тооцоолж 156.2 сая төгрөгийн элэгдлийн зардал дутуу тусгасан.	1	156,200.0	-	-	-	-	1	156,200.0	-	-	-	-
2	Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 338 ширхэг 593.3 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй байна.	1	593,340.5	-	-	-	-	1	593,340.5	-	-	-	-
3	Нийт 2,744.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага, тооцоог барагдуулах арга хэмжээг хэрэгжүүлээгүй хугацаа хэтэрсэн авлага үүсгэсэн байна.	1	2,746,262.3			1	2,746,262.3			-	-	-	-
4	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүй нийт 76.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн	1	76,360.8			1	76,360.8			-	-	-	-
5	Урт хугацаат зээл болон хүүгийн өглөгийн үлдэгдэл 2025 оны эцэст 1,296,015.2 сая компанийн нийт өр төлбөрийн 85.6 хувийг бүрдүүлсэн. Тайлант хугацаанд зээлийн хүүгийн зардал 27,631.4 сая төгрөгт хүч 62,699.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллахад голлон нөлөөлжээ. Компани нь хүүгийн зардлыг бууруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.	1	27,631,425.4			1	27,631,425.4			-	-	-	-
6	Дүн	8	31,203,589.0	-	-	3	30,454,048.5	2	749,540.5	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1052/АУ150053

Улаанбаатар хот

САТ-2026/42/НА-СТА-ТОЧ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Монголиан транс ложистик" ХХК-аас авах төмөр зам ашигласны төлбөртэй холбоотой үүссэн 688,068,790.00 (зургаан зуун наян найман сая жаран найман мянга долоон зуун ерэн) төгрөгийн авлага, Батлан хамгаалах яамтай байгуулсан газрын тосны үйлдвэрийн хотхоны 95 айлын орон сууц барих гэрээний урьдчилгаа төлбөр 2,058,193,458.00 (хоёр тэрбум тавин найман сая нэг зуун ерэн гурван мянга дөрвөн зуун тавин найман) сая төгрөг нийт 2,746,262,348.00 (хоёр тэрбум долоон зуун дөрвөн зургаан сая хоёр зуун жаран хоёр мянга гурван зуун дөчин) төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээг хэрэгжүүлээгүй хугацаа хэтэрсэн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй ." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Алтанцэцэг/, санхүү эдийн засгийн газрын дарга /Б.Чинтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Д.БЯМБАЦЭРЭН



9006109
ATA16087
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар

1053/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/42/НА-СТА-ТӨЧГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2025 оны эдийн засгийн зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөнд тодотгол хийж хэрэгжилтийг ханган ажилласан боловч үйл ажиллагааны батлагдсан зардал гүйцэтгэлээрх зардлын ангилал, зарцуулалт зөрүүтэй мөн бичиг хэрэг, шатах тослох материалыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүй 76,360,807.00 (Далан зургаан сая гурван зуун жаран мянга найман зуун долоон) төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөнд тусгалгүй шууд худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Алтанцэцэг/, санхүү эдийн засгийн газрын дарга /Б.Чинтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Д.БЯМБАЦЭРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1053/АД/150053

Улаанбаатар хот

САГ-2026/42/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Эрдэнэс Монгол” ХХК-аас Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК-д олгосон урт хугацаат зээл болон хүүгийн өглөгийн үлдэгдэл 2025 оны эцэст 1,296,015,253,681.00 (нэг их наяд хоёр зуун ерэн зургаан тэрбум арван таван сая хоёр зуун тавин гурван мянга зургаан зуун наян нэгэн) төгрөгт хүрч, компанийн нийт өр төлбөрийн 85.6 хувийг бүрдүүлсэн Тайлант хугацаанд зээлийн хүүгийн зардал 27,631,425,427.00 (хорин долоон тэрбум зургаан зуун гучин нэгэн сая дөрвөн зуун хорин таван мянга дөрвөн зуун хорин долоон) төгрөгт хүрч, 62,699,272,527.00 (жаран хоёр тэрбум зургаан зуун ерэн есөн сая хоёр зуун далан хоёр мянга таван зуун хорин долоон) төгрөгийн алдагдалтай ажиллахад нөлөөлжээ. Компани нь хүүгийн зардлыг бууруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 16-д “Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана”, 20-д “Энэ зүйлийн 16-д заасан зөвшөөрөлгүйгээр төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь зээл авах, үнэт цаас гаргахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11 “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Компанийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор авсан зээлийн хүүгийн түвшинг багасгаж компанийн алдагдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Алтанцэцэг/, санхүү эдийн засгийн газрын дарга /Б.Чинтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
“ИРМҮҮН ХАНТАЙШИР АУДИТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Д.БЯМБАЦЭРЭН